



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/194

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.9, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Гишүүнчлэлийн журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1.2.2, 7.4, "Гишүүнчлэлийн гэрээ"-ний 3 дугаар зүйлийн 3.4.2, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Өндөрхаан инвест ҮЦК" ХХК нь "Гишүүнчлэлийн журам"-д заасан гишүүнчлэлийн үйлчилгээний хөлс, арилжааны системд нэвтрэх эрх ашигласны хөлс төлөх үүргээ биелүүлээгүй тул 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн үүрэг биелэгдэх хүртэл үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлсүгэй.
2. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх эрхийг хязгаарлахыг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т тус тус даалгасугай.
3. Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлсэн компанийн талаарх холбогдох мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Монголын үнэт цаасны клирингийн төвд тус тус мэдэгдсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын алба (Ч.Эрдэнэболор)-нд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ДӨЛГӨӨН

1525033401